

Аудитын код: САГ-2018/96/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.mn

САГ-ын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням

Утас: 261885 Цахимхаяг: sambuunyamyа@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Золзаяа

Утас: 260512 Цахимхаяг: zolzayan@audit.gov.mn

Гүйцэтгэгч: Стандарт дүгнэлт аудит ХХК

Утас: 70111721



АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	8
2.9.1	Удирдлага, зохион байгуулалт.....	8
2.9.2	Нягтлан бодох бүртгэл, тайлагнал.....	8
2.9.3	Худалдан авах ажиллагаа.....	9
2.9.4	Үндсэн хөрөнгө.....	9
2.9.5	Шатах тослох материалын зардал.....	10
2.9.6	Татвар нөхөн төлүүлэх тухай.....	10
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	10
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.12	Шилэн дансны мэдээлэл.....	11
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	12
3	Менежментийн захидал.....	13
3.1	Удирдлага, зохион байгуулалт.....	14
3.2	Нягтлан бодох бүртгэл, тайлагнал.....	15
3.3	Худалдан авах ажиллагаа.....	16
3.4	Үндсэн хөрөнгө.....	17
3.5	Шатах тослох материалын зардал.....	18
4	Аудит хийгдсэн Санхүүгийн тайлан.....	19
4.1	Аудит хийгдсэн Баланс.....	19
4.2	Аудит хийгдсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан.....	21
4.3	Аудит хийгдсэн Мөнгөн гүйлгээний тайлан.....	22
4.4	Аудит хийгдсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	24



1 Аудитын гэрчилгээ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/689
танай _____-ны № _____-т

“БАГАБАЯН - ЭНХИЙН ТӨЛӨӨ
ЦОГЦОЛБОР ТӨВ” ТӨААТҮГ-ЫН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ, ХУРАНДАА
Д.БАТБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0315SAG18.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Аудитын гол асуудал

Аудитын явцад илэрсэн анхан шатны бүрдэл дутуу, хуулийн хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийсэн, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хууль тогтоомжид заасны дагуу гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, үндсэн хөрөнгийг холбогдох дансанд үнэн зөв ангилан бүртгэж, тайлагнаагүй, шатах тослох материалын бүртгэл, тооцоог зохих журмын хийж баталгаажуулдаггүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал, Иж бүрэн байх, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.


Үүрэг, хариуцлага

“Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2018\0315SAG18.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2 АУДИТЫН ТАЙЛАН

2.1 ОРШИЛ

“Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг “Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын Ерөнхий захирал, хурандаа Д.Батбаатар Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайланг батлагдсан дансны ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.8 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.


Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

“Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын 2017 оны санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тус газар санхүүгийн тайлан, тодруулгаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, тодруулгыг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 02 дугаар сарын 15-наас 2017 оны 03 дугаар сарын 12-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 15-нд үндэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөж хэрэгжүүлэв.



“Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа 2018 оны 02 дугаар сарын 15-нд Стандарт дүгнэлт аудит ХХК-д 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулсан бөгөөд аудитад баримталсан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН


Бид төлөвлөсөн бодлого, журмын дагуу Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

“Багабаян-Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ нь Бүх цэргийн жанжин Г.Дэмидийн 1932 оны 5 дугаар сарын 01-ний тушаалаар “Цэргийн дарга нарын бие сайжруулах газар” нэртэйгээр байгуулагдсан улсын ууган амралтуудын нэг юм. Батлан хамгаалах яамны сайдын тушаалаар 1978 онд Харзтайн дэнжээс “Бага баян”-д шилжүүлэн байршуулж, 2010 онд БНХАУ-ын Батлан хамгаалах яамны 6,4 сая ам.долларын буцалтгүй тусламжаар өргөтгөлийн барилга баригдаж, 2012 оны 10 дугаар сард ашиглалтад орсон байна.

Тус амралтын газрын бүтэц зохион байгуулалтыг Батлан хамгаалахын сайдын 2012 оны А/319 дугаар тушаалаар шинэчлэн баталж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн байна.

“Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ дараах үндсэн чиг үүргийг хүрээнд Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний удирдлагаас өгсөн цаг үеийн асуудлыг шийдвэрлэхээс гадна байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад ажил, үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Батлан хамгаалах салбарын харьяа цэргийн албан хаагчид, цэргийн тэтгэвэр, чөлөөнд байгаа ахмад дайчид, тэдний гэр бүлд зочид буудал, амралт, сувилал, спорт, урлаг, түүнтэй холбоотой бусад ажил үйлчилгээ үзүүлэх
- Монгол Улсын Зэвсэгт хүчнээс гадаадын улс оронд Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн цэргийн албан хаагчдыг эх орондоо ирэхэд нь нөхөн сэргээх, алжаал тайлах



Тус газрын Зочид буудал, зоогийн газрын үйлчилгээний алба, Хүний нөөц, хяналтын алба, Санхүүгийн алба, Харуул хамгаалалт, аж ахуйн албад өөрсдийн хариуцсан чиг үүргийн дагуу 2017 онд хийсэн ажил, үйл ажиллагаагаа дэлгэрэнгүй тайлагнасан байна.

“Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-А-1 маягтаар баталгаажуулсан болно.

“Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын удирдлага дараах хууль болон СТОУС, НББОУС, УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Батлан хамгаалах тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Байгаль орчны тухай хууль
- Аялал жуулчлалын тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.


2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд тус баримт бичгийг боловсруулсан боловч баталгаажуулаагүй байна.

Төлөвлөсөн горим сорилын дагуу дотоод хяналттай холбоотой

“Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг ТАБ-СТА-В-2 маягтын дагуу үнэлэхэд аудитад мэдээллийн технологийн мэргэжилтэн татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.



“Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “DAIMOND” програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

“Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулья.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 18 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг (ТАБ-СТА-А-5-1, ТАБ-СТА-А-5-2) маягтад нэгтгэж, баримтжуулав.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг (ТАБ-СТА-А-5-3) маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт 16 эрсдэлтэй асуудал тодорхойлж, түүнийг сорих 16 горим сорил боловсруулав.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт цэвэр хөрөнгийг сонгов. (ТАБ-СТА-А-4)

Цэвэр хөрөнгийг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь аж ахуйн тооцоотой газрын орлого, зарлагаас цэвэр хөрөнгө илүү тогтвортой, бодитой эдийн засгийн хувьд чухал үзүүлэлт гэдэгтэй холбоотой юм.

“Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын 2017 оны баланс дах цэвэр хөрөнгө 1,932.8 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 38.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.


Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсон нь өмнөх аудитуудаар зөрчилгүй санал дүгнэлт авч байсан, эрсдэл бага гэж үнэлсэнтэй холбоотой юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 7 чиглэлээр 16 эрсдэлтэй асуудалд 16 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. (ТАБ-СТА-В-3.1 - ТАБ-СТА-В-3.7)

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/



Аудитын явцад залруулга гараагүй.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

№	Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж болгосон асуудал	5	161.3	
2	Төлбөрийн акт тогтоосон	1	6.1	
3	Албан шаардлага өгсөн			
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн			
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн			
	Дүн	6	167.4	

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

2.9.1 Удирдлага, зохион байгуулалт

Төрийн өмчит байгууллагын хувьд тус газрын удирдлага 2017 онд дээд шатны байгууллагатай үр дүнгийн гэрээ байгуулаагүй, тайлант хугацаанд гүйцэтгэх ажил, үйл ажиллагаа, хүрэх үр дүнгийн түвшин, байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө, зардлын төсөв төлөвлөгөө батлуулж, мөрдөөгүй байна.


Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19, 20 дугаар зүйлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө зардлын төсөв төлөвлөгөө боловсруулж, батлуулан, хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх

2.9.2 Нягтлан бодох бүртгэл, тайлагнал

Тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээнээс нягтлан бодох бүртгэлийн анхан шатны болон дэлгэрэнгүй хураангуй бүртгэлийн хөтлөлтийг түүвэрлэн шалгахад бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийж, нягтлан бодох бүртгэлд тусгасан байна. Тухайлбал: Бэлэг, дурсгал, хүндэтгэлийн арга хэмжээнд зарцуулах мөнгөн хөрөнгийн бодит гүйцэтгэлийг төрөөгүй баталсан хэмжээгээр шууд зарлага болгодог, өндөр үнэтэй бэлэг дурсгалын зүйл авч зарцуулдаг байна.



Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Үйлдвэрлэл үйл ажиллагааны явцад гарсан ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгахдаа батлагдсан маягт аргачлалын дагуу хуулийн хүчин төгөлдөр анхан шатны баримт, материалыг үндэслэх зөвлөмж хүргүүлэх

2.9.3 Худалдан авах ажиллагаа

Төлөвлөсөн ёсоор худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг холбогдох баримтаар тулган баталгаажуулах горимыг гүйцэтгэхэд тус газар 2017 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулаагүй, худалдан авах ажиллагааны тайланг гаргаж, баталгаажуулаагүй байна. Зарим гүйлгээг түүвэрлэн шалгахад 2017 онд 72.5 сая төгрөгийн нүүрс нээлттэй тендер зарлалгүй Түвшин-Очир ХХК, Бекжү ХХК-тай худалдан авах гэрээ байгуулсан боловч Түвшинтөр гэдэг хувь хүнээс 24,300.0 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48, 49 дүгээр зүйлд заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж хүргүүлэх

2.9.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө бараа материалын хөдөлгөөнийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлантай тулган шалгахад 13 нэрийн 12.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хангамжийн материалын дансанд, 15 нэрийн 15.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс дансанд, биологийн хөрөнгөнд бүртгэх ёстой 20.6 сая төгрөгийн мал амьтдыг бараа, материалын дансанд тус тус хөрөнгийн ангилал буруу бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Толилуулга ба тодруулга - (Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилж, тодруулж, тайлагнасан байх) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 20 дугаар зүйлийн 20.2 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Санхүүгийн тайлан дах хөрөнгийг батлагдсан стандарт, журмын дагуу үнэн зөв ангилж, тайлагнах зөвлөмж өгөх



2.9.5 Шатах тослох материалын зардал

Тус компани 2017 онд шатах тослох материалын орлого, зарлагын гүйлгээг жолоочийн замын хуудас, орлого, зарлагын баримт, шаардах хуудас зэрэг анхан шатны баримтад бичилт хийж баримтжуулдаггүй, бараа материалын холбогдох данс бүртгэлд тусгалгүй жолооч нарын хүсэлтийн дагуу авсан мөнгөн дүнгээр нь шууд зардал болгодог байна.

Энэ нь шатах тослох материалын зардалд бүртгэлээр тавих хяналт алдагдаж, жолоочийн тооцоо, шатахуун орлого, зарцуулалт бодитой биш байх томоохон эрсдэл байгааг харуулж байна.

Шийдвэрлэсэн нь:

Шатахууны зардалд тавих хяналтыг сайжруулж, шатахууны орлого, зарлагын гүйлгээг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах зөвлөмж хүргүүлэх

2.9.6 Татвар нөхөн төлүүлэх тухай

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад Тайлант хугацаанд 4 хувь хүнээс худалдан авсан барааны үнэ 60.7 сая төгрөгөөс хүн амын орлогын албан татварт 6.1 сая төгрөгийг тооцож төсөвт төвлөрүүлээгүй байна.

Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2-т “хувиараа ажил гүйцэтгэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, үйлчилгээ үзүүлэх зэргээр олсон үйлдвэрлэл, арилжааны орлого”, 23 дугаар зүйлийн 23.2.4-д “энэ хуулийн 18, 19 дүгээр зүйл, 20.1.2-20.1.5-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар”, 26 дугаар зүйлийн 26.3-т “Суутгагч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 26.1.6-д зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Дутуу ногдуулсан Хувь хүний орлогын албан татварыг нөхөн төлүүлж, төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоов.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

1. Тайлант хугацааны авлага, өглөгийн дүнг тооцоо нийлж баталгаажуулсан эсэхийг тулган шалгахад байгууллагаас авах авлага 111.0 сая төгрөгийн 84.6 хувь буюу 93.9 сая төгрөгийн авлага "Жана наран" ХХК-тай холбоотой бөгөөд 2017 онд тооцоо нийлсэн актыг баталгаажуулаагүй байна.

Энэ нь 2014 онд амралтын 2 дугаар байрыг амралт сувиллын зориулалтаар түрээсээр ашиглуулж, түрээсийн төлбөрийг гэрээний дагуу тухай бүр аваагүйтэй холбоотой байна. Тус газар энэ асуудлыг Шүүхэд шилжүүлэн үндийдвэрлүүлэх шатандаа байна.

01

ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2. Багабаян Энхийн төлөө цогцолбор ТӨААТҮГ-ийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа 9 нэрийн 8,719.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө элэгдлийн зардлыг нөхөж дийлэхгүй гэсэн тайлбар шалтгаанаар Батлан хамгаалах яамны Зэвсэгт хүчний жанжин штабын үйлчилгээ аж ахуйн хэлтсийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байна.

Батлан хамгаалах яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас албан ёсны тайлбар, тодруулга авч, асуудлыг шийдвэрлэх зөвлөмж аудитын явцад өгөв.

3. Тус газар Батлан хамгаалах яамны захиалгаар гүйцэтгэсэн 4 ажил үйлчилгээ үзүүлэхэд гарсан 33.4 сая төгрөг зарцуулж, тайлант хугацааны зардал болгосон бөгөөд байгууллагад санхүүгийн дарамт болж байна гэж үзэж, эдгээр арга хэмжээнд зарцуулсан зардлын эх үүсвэрийг Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас гаргаж, тооцох хүсэлт гаргасан боловч, тодорхой шийдэлд хүрээгүй байна.

Дээд газраас гаргасан тодорхойгүй, алдаатай шийдвэрийн талаар тухай бүр тайлбар, тодруулга авч байх зөвлөмжийг аудитын явцад өгөв

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Энэхүү тайлангийн 2.9.1-д дурдсаны дагуу тус газрын тайлант хугацаанд төвлөрүүлэх орлого, үйл ажиллагааны зарлагыг баталгаажуулаагүй байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

“Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн (<http://www.mod.gov.mn/bagabayan.html>) цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах тухай зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна. Тухайлбал: худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хууль тогтоомжид заасны дагуу боловсруулж, баталгаажуулаагүй нь худалдан авах ажиллагаанд хяналт тавих боломжгүй болгосны гадна нүүрс, хүнсний материал зэрэг бараа, ажил, үйлчилгээг худалдан авахдаа нээлттэй болон хязгаарлагдмал тендер зарласан гэх боловч холбогдох журмын дагуу нотлох зүйлээр баримтжуулаагүй, өмнөх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.

Иймд 2017 онд худалдан авсан нүүрс нийлүүлэх гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ хууль тогтоомж зөрчсөн эсэх асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлж шалгуулах нь зүйтэй гэж үзлээ.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримтын материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.



2.14 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид “Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол “Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Аудитын гол асуудал

Аудитын явцад илэрсэн бүрдэл дутуу, хуулийн хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийдэг, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг хууль тогтоомжид заасны дагуу гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьдаггүй, үндсэн хөрөнгийг холбогдох дансанд үнэн зөв ангилан бүртгэж, тайлагнаагүй, шатах тослох материалын бүртгэл, тооцоог зохих журмын хийж баталгаажуулдаггүй зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн Толилуулга ба тодруулга, Үнэн зөв байдал, Иж бүрэн байх, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг менежментийн захидалд тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс их байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэл болсон.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Багабаян - Энхийн төлөө цогцолбор төв” ТӨААТҮГ-ын нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.



3.1 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Илрүүлэлт

Төрийн өмчит байгууллагын хувьд тус газрын удирдлага 2017 онд дээд шатны байгууллагатай үр дүнгийн гэрээ байгуулаагүй, тайлант хугацаанд гүйцэтгэх ажил, үйл ажиллагаа, хүрэх үр дүнгийн түвшин, байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө, зардлын төсөв төлөвлөгөө батлуулж, мөрдөөгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19, 20 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна. Энэхүү замбараагүй байдал нь удирдлагууд удаа дараалан солигдож тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдах, ажлын гүйцэтгэл, үр дүнд тавих хяналт сулрах шалтгаан болжээ.

Эрсдэл

Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаанд хяналт тавих боломжгүй болж, дотоод хяналт сулрах

Үнэн зөв байдал батламж мэдэгдэл зөрчигдөх,

Зөвлөмж

Байгууллагын үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгө зардлын төсөв төлөвлөгөө боловсруулж, батлуулан, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19, 20 дугаар зүйлийг хэрэгжүүлж ажиллах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 10 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.2 Нягтлан бодох бүртгэл, тайлагнал

Илрүүлэлт

Тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээнээс нягтлан бодох бүртгэлийн анхан шатны болон дэлгэрэнгүй хураангуй бүртгэлийн хөтлөлтийг түүвэрлэн шалгахад бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар ажил гүйлгээ хийж, нягтлан бодох бүртгэлд тусгасан байна. Тухайлбал: Бэлэг, дурсгал, хүндэтгэлийн арга хэмжээнд зарцуулах мөнгөн хөрөнгийн бодит гүйцэтгэлийг тооцолгүй баталсан хэмжээгээр шууд зарлага болгодог, өндөр үнэтэй бэлэг дурсгалын зүйл авч зарцуулдаг байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13.4-д “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын 2002 оны 171/111 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

Эрсдэл

Үнэн зөв байдал, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдэл зөрчигдөх,

Зөвлөмж

Үйлдвэрлэл үйл ажиллагааны явцад гарсан ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэл, тайланд тусгахдаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон батлагдсан маягт аргачлалын дагуу хуулийн хүчин төгөлдөр анхан шатны баримт, материалыг үндэслэх, хуулийн хүчин төгөлдөр бус баримтаар гүйлгээ хийгүй байх

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.3 Худалдан авах ажиллагаа

Илрүүлэлт

Төлөвлөсөн ёсоор худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг холбогдох баримтаар тулган баталгаажуулах горимыг гүйцэтгэхэд тус газар 2017 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулаагүй, худалдан авах ажиллагааны тайланг гаргаж, баталгаажуулаагүй байна. Зарим гүйлгээг түүвэрлэн шалгахад 2017 онд 72,484.0 мянган төгрөгийн нүүрс нээлттэй тендер зарлалгүй Түвшин-Очир ХХК, Бекжү ХХК-тай худалдан авах гэрээ байгуулсан боловч Түвшинтөр гэдэг хувь хүнээс 24,300.0 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48, 49 дүгээр зүйлд заасан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүйтэй холбоотой байна.

Эрсдэл

Үнэн зөв байдал, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдэл зөрчигдөх,

Зөвлөмж

Тайлант хугацаанд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг холбогдох журмын дагуу боловсруулж, баталгаажуулан хэрэгжилтийг зохион байгуулах, тайлагнах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, тогтоомжийн дагуу хийх.

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

3.4 Үндсэн хөрөнгө

Илрүүлэлт

Үндсэн хөрөнгө бараа материалын хөдөлгөөнийг нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлантай тулган шалгахад 13 нэрийн 12,913.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг хангамжийн материалын дансанд, 15 нэрийн 15,169.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бага үнэтэй түргэн элэгдэх эд зүйлс дансанд, биологийн хөрөнгөнд бүртгэх ёстой 20,653.5 мянган төгрөгийн мал амьтдыг бараа, материалын дансанд тус тус хөрөнгийн ангилал буруу бүртгэж, тайлагнасан байна.

Энэ нь Толилуулга ба тодруулга - (Аж ахуйн нэгж, байгууллага санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилж, тодруулж, тайлагнасан байх) батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 20 дугаар зүйлийн 20.2 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

Эрсдэл

Үнэн зөв байдал, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдэл зөрчигдөх,

Зөвлөмж

Санхүүгийн тайлан дах хөрөнгийг тооллогын комисс томилон батлагдсан стандарт, журмын дагуу үнэн зөв ангилж, баталгаажуулан, тэрхүү шийдвэрийг үндэслэн санхүүгийн тайлан, тодруулгад залруулга хийх арга хэмжээ авах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

3.5 ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛЫН ЗАРДАЛ

Илрүүлэлт

Тус компани 2015, 2016, 2017 онд шатах тослох материалын орлого, зарлагын гүйлгээг жолоочийн замын хуудас, орлого, зарлагын баримт, шаардах хуудас зэрэг анхан шатны баримтад бичилт хийж баримтжуулдаггүй, бараа материалын холбогдох данс бүртгэлд тусгалгүй жолооч нарын хүсэлтийн дагуу авсан мөнгөн дүнгээр нь шууд зардал болгодог байна.

Энэ нь шатах тослох материалын зардалд бүртгэлээр тавих хяналт алдагдаж, жолоочийн тооцоо, шатахуун орлого, зарцуулалт бодитой биш байх томоохон эрсдэл байгааг харуулж байна.

Эрсдэл

Үнэн зөв байдал, Толилуулга ба тодруулга батламж мэдэгдэл зөрчигдөх,

Зөвлөмж

Шатахууны зардалд тавих хяналтыг сайжруулж, шатахууны орлого, зарлагын гүйлгээг холбогдох анхан шатны баримтаар баталгаажуулан нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгах ажлыг зохион байгуулах

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 6 дугаар сарын 20-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлнэ үү.

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлнэ

01


ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ХЯЗГААРЛАЛТАЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

4 АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийгдсэн БАЛАНС

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Балансын зүйл	2017-01-01	2017-12-31
1	ХӨРӨНГӨ	0.00	0.00
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	54,599,617.41	45,272,044.98
1.1.2	Дансны авлага	87,776,085.13	117,769,969.42
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	0.00	436,028.04
1.1.4	Бусад авлага	0.00	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	272,830,285.18	269,412,645.69
1.1.7	Урьдчилж төлсөн зардал тооцоо	0.00	0.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	19,853,498.85	20,653,506.51
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	435,059,486.57	453,544,194.64
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,458,106,969.76	1,569,599,051.39
1.2.2	Биет бус хөрөнгө	3,471,185.50	1,977,477.57
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,461,578,155.26	1,571,576,528.96
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,896,637,641.83	2,025,120,723.60
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	ӨР ТӨЛБӨР	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.1	Дансны өглөг	13,763,850.91	19,898,624.72
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	37,540,215.73	90,665,067.49
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
2.1.1.9	Нөөц / өр төлбөр /	0.00	0.00



2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	2,379,600.00	3,467,800.00
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)- нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	53,683,666.64	114,767,792.21
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.1	Урт хугацаат зээл	0.00	0.00
2.1.2.2	Нөөц / өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	2,314,596.25	1,036,065.04
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	2,314,596.25	1,036,065.04
2.2	Өр төлбөрийн нийт дүн	55,998,262.89	115,803,857.25
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.1	Төрийн өмч	943,008,420.00	943,008,420.00
2.3.2	Хувийн өмч	0.00	0.00
2.3.3	Хувьцаат өр төлбөр	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	12,558,676.16	12,558,676.16
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	580,892,169.99	580,892,169.99
2.3.9	Хуримтлагдсан ашиг	304,180,112.79	372,857,600.20
2.3.20	Эздийн өмчийн дүн	1,840,639,378.94	1,909,316,866.35
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	1,896,637,641.83	2,025,120,723.60

4.2 Аудит хийгдсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017-01-01	2017-12-31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,065,832,083.35	1,111,992,878.67
2	Борлуулалтын өртөг	873,078,435.10	892,332,134.89
3	Нийт ашиг (алдагдал)	192,753,648.25	219,660,743.78
4	Түрээсийн орлого	56,198,191.89	23,098,424.99
5	Хүүгийн орлого	780,710.84	650,378.28
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Хөрөнгөөрх орлого	0.00	89,998,986.00
8	Бусад орлого	37,561,814.00	51,874,955.39
9	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	293,686,133.89	248,557,954.36
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	30,888,072.98	43,075,097.06
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	-17,342,117.68
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-37,279,841.89	76,308,319.34
19	Орлогын татварын зардал	1,733,524.99	7,630,831.93
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-39,013,366.88	68,677,487.41
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-39,013,366.88	68,677,487.41
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	-39,013,366.88	68,677,487.41
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00



4.3 Аудит хийгдсэн Мөнгөн гүйлгээний тайлан

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2017-01-01	2017-12-31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,281,639,006.60	1,283,695,766.91
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	1,199,361,006.76	1,197,288,701.36
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	81,602,599.84	84,679,394.97
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	675,400.00	1,727,670.58
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,236,566,740.42	1,293,673,717.62
1.2.1	Ажиллагчдад төлсөн	172,378,673.00	210,450,354.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	86,914,687.76	78,799,085.25
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	638,156,011.30	777,010,657.65
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	97,481,211.75	81,383,250.91
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	21,301,501.57	9,856,903.82
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	158,091,064.73	89,012,781.84
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	297,000.00	108,500.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	61,615,910.31	47,052,184.15
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	45,072,266.18	-9,977,950.71
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	780,710.84	650,378.28
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	780,710.84	650,378.28
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	650,378.28	650,378.28
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00



3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
3.1.3	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
3.1.4	Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг	0.00	0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж төлсөн	0.00	0.00
3.2.4	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
3.2.5	Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	45,852,977.02	-9,327,572.43
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,746,640.39	54,599,617.41
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	54,599,617.41	45,272,044.98

4.4 Аудит хийгдсэн Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан (төгрөгөөр)

	Үзүүлэлт	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	943,008,420.00	16,081,144.95	12,558,676.16	564,811,025.04	343,193,479.67	1,879,652,745.82
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
3	Залруулсан үлдэгдэл	943,008,420.00	16,081,144.95	12,558,676.16	564,811,025.04	343,193,479.67	1,879,652,745.82
4	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	16,081,144.95	0.00	16,081,144.95
6	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
7	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	-39,013,366.88	-39,013,366.88
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
9	2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	943,008,420.00	0.00	12,558,676.16	580,892,169.99	304,180,112.79	1,840,639,378.94
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	943,008,420.00	0.00	12,558,676.16	580,892,169.99	304,180,112.79	1,840,639,378.94
12	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
13	Өмчид гаргасан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
14	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
15	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	68,677,487.41	68,677,487.41
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
17	2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	943,008,420.00	0.00	12,558,676.16	580,892,169.99	372,857,600.20	1,909,316,866.35

